



Хэнтий аймгийн хөдөө аж ахуйн салбарын санаачлагыг дэмжих бичил төслийн шалгаруулалт

1 АГУУЛГА

“Хөдөөгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн тэгш оролцоог хангах нь” буюу ИМПАКТ төсөл нь Хэнтий аймгийн зорилтот сумдад үйл ажиллагаа эрхэлдэг хөдөө аж ахуйн салбарын цөөн тооны үйлдвэрлэгч бүлгүүд болон иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих зорилгоор **бичил төслийн тэтгэлэг зарлаж байна.**

ИМПАКТ төсөл нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлж, тогтвортой ноолуур, органик хүнсний ногоо тариалалтын сайн туршлагаудыг бий болгох замаар үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийг чадваржуулж, шийдвэр гаргах үйл явцад оролцдог, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

Төслийг Хил Хязгааргүй Малын Эмч нар ба Агрономчид (AVSF) ОУБ Сэргээгдэх эрчим хүч ба эв санааны нэгдлийн групп (GERES) ОУБ болон Монголын Эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-тай хамтран Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлдэг билээ.

ИМПАКТ төсөл нь Хэнтий аймгийн **Мөрөн, Биндэр, Хэрлэн** сумдад дараах дэд зорилтыг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Зорилт 1: Орлогын эх үүсвэр бий болгох үйл ажиллагаа, хоршооны болон өрхийн санхүүгээ удирдахад эмэгтэйчүүдийн бүлгийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
2. Зорилт 2: Өндөр үр ашигтай хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих замаар эмэгтэйчүүдийн бүлгүүдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх
3. Зорилт 3: Харилцан дэмжлэг үзүүлэх, орон нутагт бодлого хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн бүлгүүдийн, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай харилцан зөвшилцөх, хамтран ажиллах чадварыг сайжруулах
4. Зорилт 4: ХАА-н үр ашигтай тогтолцоонд эмэгтэйчүүдийн бүлгүүдийн үүрэг роль, тэдний орон нутгийн болон үндэсний хэмжээний төлөөллийг чадавхижуулах

2 БИЧИЛ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Энэхүү буцалтгүй тусламжийн бичил хөтөлбөрөөр ноолуур, хүнсний ногооны салбар дахь орон нутгийн санаачлагыг дэмжиж, урамшуулахаар төлөвлөсөн билээ. Орон нутгаас гарсан санал санаачлагууд нь тэтгэлэгт оролцогчийн үйлдвэрлэл, маркетинг эсвэл байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилтыг агуулсан байж болох бөгөөд орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгүүд, эмэгтэй удирдлага бүхий иргэний нийгмийн байгууллагуудад давуу эрх олгоно.

Уг тэтгэлэгт хөтөлбөр нь органик хүнсний ногоо, тогтвортой ноолуурын чиглэлээр эдийн засгийн нөөц боломж байгааг бусад үйлдвэрлэгч бүлгүүд, орон нутгийн болон улсын хэмжээний удирдлагын түвшинд харуулж, эмэгтэй удирдлага бүхий сонгогдсон ИНБ-уудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хөтөлбөр нь эцсийн дүндээ ноолуурын нэмүү өртгийн сүлжээ, хүнсний ногооны үйлдвэрлэлийн салбарын Иргэний нийгмийн байгууллагуудын (эмэгтэй удирдлагатай эсвэл эмэгтэйчүүдэд чиглэсэн) оролцоог сайжруулах, чадавхийг бэхжүүлэх түүнчлэн сумдын болон аймгийн төвд хүнсний ногооны хүртээмжийг сайжруулах, ноолуурын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Бичил төслийн хүрээнд сонгогдсон иргэний нийгмийн байгууллагууд нь орон нутагтаа органик хүнсний ногоо тариалах, тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлэх хугацаанд техникийн болон санхүүгийн дэмжлэг авах юм.

АНХААРУУЛГА:

Тэтгэлэг нь хэрэгжүүлэх төслийн төсвийн 75%-ийг буцалтгүй тусламжаар олгоно.
Төсвийн дүнгийн үлдсэн хувийг тэтгэлэг хүсэгч өөрийн хөрөнгөөр эсвэл
БУСАД САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС ГАРГАНА.

3 НИЙТ ТЭТГЭЛГИЙН ТОО БОЛОН ҮНИЙН ДҮН:

Хэнтий аймагт 3-н төсөл сонгон шалгаруулах бөгөөд нэгж төслийн санхүүжилт 7,500 евро (долоон мянга таван зуун евро) буюу 25,500,000 төгрөг (хорин таван сая таван зуун мянган төг) байна.

4 БИЧИЛ ТЭТГЭЛЭГТ ХЭН ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

- Зөвхөн зорилтот сумдад Ноолуурын нэмүү өртгийн сүлжээ болон хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг байгууллагууд

- Хууль ёсны бүртгэлтэй иргэний нийгмийн байгууллагууд /Малчид, ногооны аж ахуй эрхлэгч орон нутгийн эмэгтэйчүүдийн бүлгүүдийг хамруулсан ТББ, Хоршоо/
- Удирдлага болон тэргүүлэгчид нь наад зах нь 1-3 эмэгтэй гишүүнтэй байгууллага байх
- Зөвхөн төслийн үйл ажиллагаа хэрэгжиж буй аймгийн зорилтот сумдын ИНБ-д байх:

Хэнтий аймаг
Хэрлэн сум Мөрөн сум Биндэр сум

АНХААРУУЛГА: Бичил тэтгэлгийг шалгаруулах комиссын гишүүн ИНБ тэтгэлэгт хөтөлбөрт оролцох боломжгүй.

5 ОРОЛЦОХ САНАЛАА ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

Тэтгэлэг хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн төслийн багт **2021 оны 07 сарын 30-ны** дотор хүргүүлнэ.

- Төслийн хураангуй агуулга
 - Эхний хэсэг: Төслийн санал ба үндэслэл
 - Хоёрдахь хэсэг: Байгууллагын тодорхойлолт
 - Гуравдахь хэсэг: Маркетингийн төлөвлөгөө
 - Дөрөвдэх хэсэг: Үйл ажиллагааны ба санхүүгийн төлөвлөгөө
- Хавсралт 1: Байгууллагатай холбогдох утасны жагсаалт
- Хавсралт 2: Бизнес төлөвлөгөө
- ИНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ба холбогдох хүний иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана.

АНХААРУУЛГА: Тэтгэлгийн саналын маягт дээр худал мэдээлэл оруулсан нөхцөлд сонгогдох боломжгүй.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл тэтгэлэгтэй холбоотой асуудлаар асууж тодруулах зүйл байвал төслийн багийн гишүүдтэй доорхи утас болон цахим хаягаар холбогдож болно.

Зөвшөөрөгдөх зардал болон санхүүгийн дэмжлэг авах:

- Үйл ажиллагааны чиглэл:
 - **Органик хүнсний ногоо үйлдвэрлэл:** Нарны эрчим хүчээр ажилладаг хүлэмж, эко-зоорь (биоклиматик), багаж хэрэгсэл, ногоо боловсруулах, хадгалах хэрэгсэл, эко савлагаа гэх мэт...
 - **Тогтвортой ноолуур үйлдвэрлэл:** агуулах, малын тэжээл үйлдвэрлэлийн ба мал эмнэлгийн тоног төхөөрөмж, бэлчээрийн менежментийн үйл

ажиллагаа /худаг, булаг шандны эх, бэлчээр хаших/ малын үүлдэр угсаа сайжруулах болон бусад холбогдох үйл ажиллагаа

- Иргэний нийгмийн байгууллагын одоогийн хүчин чадалд тохирсон жижиг үйлдвэрлэлийн нэгжид тохирсон малын ноос ноолуур эсвэл хүнсний ногооны үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийн хэсэгчилсэн зардал
- Бараа бүтээгдэхүүний борлуулалт болон маркетингийн хэсэгчилсэн зардал

6 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Бичил тэтгэлэгт төслийн сонголтыг Төсөл шалгаруулах комисс шалгаруулна. Төсөл шалгаруулах комисс нь “ИМПАКТ” төслийн удирдлага, аймаг тус бүрт байрлах төслийн багийн удирдлагаас гадна зорилтот аймгийн ЗДТГ, ХАА-н газар, жендэрийн болон ИНБ-дын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

7 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- **Тэтгэлэг хүсэгч байгууллагын хүйсийн харьцаа ба оролцоо**
- **Төслийн үндэслэл, агуулга ба оновчтой байдал**
 - Техникийн болон эдийн засгийн нөхцөл байдал
 - Ашиг шим хүртэгчдийн тоо
- **Төслийн санхүүгийн тооцоолол, үндэслэл ба оновчтой байдал**
 - Санхүүгийн хувьд бодитой, оновчтой эсэх
 - Зах зээлийн хэмжээ, нөөц бололцоо
- **Тэтгэлэгт төслийн саналын нийт төсвийн 75%-д хийсэн санхүүгийн тооцоолол**
- **Хамтран санхүүжүүлэхээр санал болгох загварыг тодорхойлох**

Төслийн төсвийн үлдсэн 25%-ийг бүрдүүлэх эх үүсвэр (банкны зээл & барьцаа хөрөнгө, хадгаламж, Орон нутгийн удирдах байгууллагын сангийн хандив)

8 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ХУВААРЬ

- 2021 оны 7 сарын 5-6: Бичил тэтгэлэг шалгаруулах болзол, мэдээлэл түгээх
- 2021 оны 7 сарын 30 Тэтгэлэг горилох бичил төсөл хүлээн авах эцсийн хугацаа
- 2021 оны 8 сарын 6: Сонгон шалгаруулалт
- 2021 оны 8 сарын 10-20: Шалгарсан Иргэний нийгмийн байгууллагатай гэрээ хийх
- 2021 оны 8 сарын 20 Төсөл хэрэгжиж эхлэх хугацаа
- 2021 оны 10 сарын 1: Тэтгэлгийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх

9 БИЧИЛ ТЭТГЭЛЭГ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ

- Ашиг хүртэгч талтай төслийг хамтран санхүүжүүлэхэд хувь нэмрээ оруулах **хатуу гэрээ байгуулна.**

- Гэрээний дагуу хийгдэх төслийн хэрэгжилт болон санхүүгийн ил тод байдал дээр төслийн багаас хяналт тавих эрхтэй.
- Хэрэгжилтийн явцаас шалтгаалан төслийн санхүүжилтийг урьдчилан ба хэсэгчлэн олгож, зарцуулалтанд хяналт тавина.
- Гэрээг Монгол улсын хуулийн хүрээнд хийх ба гэрээний үүрэг зөрчигдсөн нөхцөлд хуулийн байгууллагад хандана.

Холбоо барих:

Нэр	Албан тушаал	Утасны дугаар	Email хаяг
Ц. Үүрцайх	Орон нутгийн зохицуулагч	91114758	ts.uurtsaikh@avsf.org
Ц. Мөнгөнцэцэг	Нэмүү өртгийн сүлжээний эксперт	96003549	t.munguntsetseg@avsf.org